

“БАРИЛГА” КОРПОРАЦИ

**“БАРИЛГА” КОРПОРАЦИ (ХК)-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

*(2009 оны үйл ажиллагааны
үр дүнгийн тухай)*

Улаанбаатар хот
2010 оны 04-р сар



БАРИЛГЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ
ХУДАЛДАА, ЗУУЧЛАЛЫН
“БАРИЛГА” КОРПОРАЦИ
manufacture, trade, construction & investment

2010 оны ⁰⁴ дугаар
сарын ²⁷-ний өдөр

Дугаар...^{01/55}


Улаанбаатар
хот.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Материал хүргүүлэх тухай.

Тус “Барилга” корпораци ХК нь 2010 оны 04-р сарын 23-ны өдөр 2009 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг хуралдуулав.

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн талаарх материалыг хүргүүлэв.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ.


Ш.ЭРДЭНЭБАТ

ТОВЬЁОГ

1. “Барилга” корпораци ХК-ийн ТУЗ-ийн тогтоол №01/04
2. Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл
3. Хурлын зар /сонингийн/
4. Хурлын зар гаргах тухай бичиг
5. Компанийн хувьцааны тархалтын товчоо
6. Хурлын тэмдэглэл
7. Хурлын тогтоол №1
8. Хурлын тогтоол №2
9. Хурлын тогтоол №3
10. Хурлын тогтоол №4
11. Хурлын тогтоол №5
12. Хурлын тогтоол №6
13. Хурлын тогтоол №7
14. ТУЗ-ийн тайлан
15. Компанийн гүйцэтгэх захирлын тайлан
16. Санхүүгийн тайлан
17. Хянан шалгагчийн тайлан
18. Аудиторын дүгнэлт
19. 2009 оны санхүүгийн тайлан

“БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 03 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 01/04

Улаанбаатар
хот.

Хувь нийлүүлэгчдийн
хуралд бэлтгэх тухай

Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоох нь:

1. “Барилга” ХК корпорацийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг 2010 оны 04-р сарын 23-ны дотор хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувь нийлүүлэгчдийн хуралд бэлтгэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
Хэсгийн дарга – Ш.Эрдэнэбат
Гишүүд – В.Мөнхгэрэл
Д.Гэрэлцэцэг
3. Комисст даалгах нь:
 - Корпорацийн ТУЗ, хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг үнэн зөв бэлтгүүлж ТУЗ-д урьдчилан танилцуулах.
 - Корпорацийн 2010 оны үйл ажиллагааны чиглэл, бизнес төлөвлөгөөний төслийг бэлтгэх.
 - Бусад асуудлуудыг бэлтгэх
4. Комиссын ажилд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг гүйцэтгэх захиралд даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА


Л.ШАГДАРРАГЧАА

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр: “Барилга” ХК
Хаяг, утас: 313247, 321420

Хувь нийлүүлэгчид ээлжит / ээлжит бус / хурал/ алин болохын доогуур нь зур/

Хуралдах огноо, цаг, газар: 2010 оны 04-р сарын 23-ны өдрийн 10 цагт
“Барилга” корпорацийн хурлын танхимд

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: 2010.03.02-ны өдөр

Олон нийтэд зарлах огноо: 2010.03.09-ны өдөр

Бүртгэх өдөр: 2010.03.22-ны өдөр.

Гэрээний дагуу хурлын баримт бичгийг Хөрөнгийг биржид хүргүүлэх
огноо: 2010.04.28-ны өдөр. /online-аар/

Хүргүүлсэн огноо: 2010.04.28-ны өдөр.

Хурлын баримт бичгийн хуудсын тоо:³⁹ хуудас



ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН

ДАРГА.

/Ш.ЭРДЭНЭБАТ/

2010 оны 03-р сарын 02-ны өдөр.

ХҮЛЭЭЖ АВСАН БҮРТГЭЛИЙН

МЭРГЭЖИЛТЭН/...../

1. Хурлын зарыг “Зууны мэдээ”, “Өнөөдөр”, “Өдрийн сонин” гэх зэрэг өдөр тутмын сонинд заавал зарлахын зэрэгцээ, үндэсний радио, телевизээр зарлана.
2. Бүртгэх өдрөөр хувьцаа эзэмшиж байгаа гишүүд хуралд оролцоно.
3. Энэхүү мэдээллийг 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус ирүүлнэ.

**“БАРИЛГА” ХК
КОРПОРАЦИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЭД**

“Барилга” ХК корпорацийн
ТУЗ-ийн хурлын шийдвэрээр
тус компанийн хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурлыг
**2010 оны дөрөвдүгээр
сарын 23-ны 10.00 цагт** тус
корпорацийн хурлын танхимд
хийнэ.

Хурлаар:

- ТУЗ-ийн тайлан
- Хянан шалгагчийн тайлан
- 2009 оны санхүүгийн тайлан
- 2010 оны үйл ажиллагааны
чиглэл
- Зохион байгуулалтын болон
бусад асуудлыг хэлэлцэнэ.

Хурлаас гарах шийдвэр, баримт
бичгийг хувьцаа эзэмшигчдэд
урьдчилан биечлэн хүргүүлж,
холбогдох брокерийн пүүсүүдэд
хүргүүлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн
хуралдаа оролцохыг урьж
байна.

**ХУРАЛ ЗОХИОН
БАЙГУУЛАХ КОМИСС**
Утас: 313247, 88112979

**“БАРИЛГА” ХК-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ
Н..... ТАНАА**

Хурлын зар хүргэх тухай.

“Барилга” ХК-ний 2009 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, 2010 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн талаар хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг 2010 оны 04-р сарын 23-ний өдрийн 10⁰⁰ цагаас компаний хурлын байранд хуралдуулахаар ТУЗ-өөс шийдвэрлэсний дагуу хуралд оролцохыг урьж байна.

Хурлаар доорх асуудлыг хэлэлцэх болно.

1. ТУЗ-ийн тайлан
2. 2009 оны компанийн үйл ажиллагааны тайлан, 2010 оны үйл ажиллагааны чиглэл
3. 2009 оны санхүүгийн тайлан
4. Хянан шалгагчийн тайлан
5. Зохион байгуулалтын болон бусад асуудлууд

Зохион байгуулалтын болон бусад асуудлыг хэлэлцэнэ Хурлаас гарах шийдвэр болон баримт бичгийг хавсаргав.



Хуралд бэлтгэх ажлын
хэсгийн ахлагч.

Ш.ЭРДЭНЭБАТ

**“БАРИЛГА” (ХК) КОРПОРАЦИЙН
ХУВЬЦААНЫ ТАРХАЛТЫН ТОВЧОО**

№	Хувьцаа эзэмшигчид	Регистр	Хувьцааны тоо	Эзлэх хувь	
1	“Хаш орд” ХХК	Д.Алтангэрэл	ЧП58021875	1	0.002%
2	“Гангар инвест” ХХК	Д.Очгэрэл	ЦБ51022105	2	0.005%
3	“Орд харш” ХХК	Баатаржав	Ш349112533	2	0.005%
4	“Асар” ХХК	Ж.Галбадрах	ЧП48091415	4	0.010%
5	“Инкон” ХХК	Д.Туул	ЦБ57122305	5	0.012%
6	“Монинжбар” ХХК	Г.Буд	ХП46020616	5	0.012%
7	“Гангар” ХХК	Туяа	ЦЕ63042904	6	0.015%
8	“БҮК” ХК	Н.Хажет	ТА54111876	8	0.020%
9		Д.Төмөртулга	ЧИ48032213	10	0.025%
10	“Зая бандид” ХХК	Д.Бэгзээ	ЧР51030171	10	0.025%
11	“Сонсголон бармат” ХК	С.Сүхбаатар	ХВ59121579	10	0.025%
12	“Бодтойдүнжингарав” ХХК	В.Мангалсүрэн	ХП41032379	30	0.074%
13	“Монтёр” ХХК	Г.Ганболд	Ш357052478	37	0.091%
14	“Нийслэл өргөө” ХК	Я.Жадамбаа	ЧП48122214	5	0.012%
15	“Хүрд” ХХК	Энхжаргал	УШ55111911	75	0.184%
16	“Зэндмэнэ инвест” ХХК	Ж.Гантөмөр	ЧП61020235	75	0.184%
17	“Монмосбарилга” ХХК	Г.Болд	PE42111375	300	0.738%
18	“Бармон” ХХК	Б.Бурмаа	ЧП52042967	5000	12.296%
19		Б.Энхболд	ХП50120273	1010	2.484%
20		Ш.Эрдэнэбат	ЧП73091771	6780	16.674%
21		Ш.Үнэнбат	ЧП74120774	5000	12.296%
22		Л.Шагдаррагчаа	ЧП51111079	8651	21.275%
23		Ш.Төгсбат	ЧП78071677	3000	7.378%
24		Ш.Ариунбат	ЧП77030771	9636	23.698%
25		С.Тунгалаг	ЧБ76040108	1000	2.459%
	НИЙТ ДҮН			40662	100%



(Handwritten signature)

В.МӨНХГЭРЭЛ

**“БАРИЛГА” КОРПОРАЦИ ХК-ИЙН 2010 ОНЫ
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2010 оны 04 дугаар
сарын 23-ний өдөр.

Улаанбаатар
хот.

Хурлыг “Барилга” корпорацийн хурлын танхимд 10⁰⁰ цагт эхлүүлэв.

ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа хуралд хувьцаа эзэмшигчдийн 98.5%-ийн төлөөлөл ирснийг мэдэгдэж хурал эхлэх талаар санал хураахад гишүүд санал нэгтэй батлаж хурлыг эхлүүлэв.

Ингээд хурлын тэргүүлэгчдийг сонгох ажиллагаа явагдав. Хурлын даргаар Л.Шагдаррагчаа, гишүүдэд Б.Бурмаа, Ш.Эрдэнэбат нар сонгогдов. Хурлын дарга Л.Шагдаррагчаа хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав. Хуралд хэлэлцэх асуудал, хурлын дэгийг санал нэгтэй батлаж тогтоол гаргахаар болов.

Хурлын дэгийн дагуу гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат компанийн 2009 оны үйл ажиллагааны тайлан, 2010 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн талаар тайлан хэлэлцүүлэв. ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа ТУЗ-ийн тайланг хэлэлцүүлэв. Компанийн ерөнхий санхүүч Д.Гэрэлцэцэг 2009 оны балансын дүнг танилцуулав. Хянан шалгагч С.Тунгалаг хянан шалгагчийн тайланг хэлэлцүүлэв.

Компанийн дүрмийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг болон хянан шалгагчийг жил бүр сонгох ёстой боловч ТУЗ-ийн даргын оруулсан саналын дагуу 2009 онд сонгогдсон ТУЗ-ийн гишүүд, хянан шалгагчийг улируулан ажиллах асуудлыг хувьцаа эзэмшигчид санал нэгтэй зөвшөөрч дахин сонгууль явуулах шаардлагагүй гэж үзэв. Ингээд тайлангуудын талаар асуулт асууж хариулт авав.

Л.Шагдаррагчаа: Хэлэлцэх асуудал, тайлангуудаа танилцууллаа. Энэ 4 тайлангаас асуух тодруулах зүйл байна уу?

Д.Гэрэлцэцэг – Миний ажлаа авсанаас өмнөх балансад тусгагдсан байсан өр төлбөрүүдийг цэгцлээд нэг үеэ бодвол баланс эрүүлжээд байгаа. Эзэн холбогдогч нь олдохгүй байгаа зээлийн 100-аад сая төгрөгийн авлага байгаа.

Ш.Эрдэнэбат – “Намуун дэнж” төсөлд авсан зээлийн төлбөрүүдээс 2009 онд иргэн Б.Батбаатарын 186.0 сая төгрөг, иргэдийн 65.2 мянган ам.долларын өрийг төлөөд дуусгасан. Одоо иргэдэд 20.9 мянган ам.доллар, 2 банкнаас авсан банкны зээлийн төлбөрүүд л үлдсэн.

Л.Шагдаррагчаа – Өмнөх онуудын ногдол ашгаас хувьцаа эзэмшигчдэд олгогдоогүй байгаа ногдол ашиг байгаа юу? Байгаа бол энэ онд олгох боломж байна уу?

Д.Гэрэлцэцэг – 6-р сараас мөнгөний хуримтлал үүсэх тооцоо байгаа. Тэр үед олгогдоогүй ногдол ашгийг нөхөж олгох боломжтой болно.

Б.Бурмаа – Корпорацийн үйл ажиллагааг ерөнхийд нь мэдэж байгаа. 2009 онд компани сайн ажилласан байна. Татваруудыг цаг хугацаанд нь төлж, өр төлбөрөөс нилээд хэмжээгээр төлжээ. Сайн байна гэж сайшааж байна. Ер нь хувь нийлүүлэгчдийн хуралд авах авлага, өр төлбөрийг дэлгэрэнгүй эзэн холбогдогчтой нь өгч баймаар байна. Бизнесийн харилцаа холбоо үүсэх тохиолдолд өр төлбөрийг суутган тооцож байх боломжтой тул хувьцаа эзэмшигчид мэдэж байх шаардлагатай байна.

Ш.Эрдэнэбат – Корпорацийн хувьд тендерийн материалыг авч ажлаа авсанаас хойш бүх ажилчид сайн ажиллаж байгаа. Ачаалал ихтэй байна. Одоогоор Айвенхоу майнз компанийн зүгээс олон ажлыг санал болгож байгаа. Энэ ажлуудыг авч бэлэн мөнгөний хуримтлал үүсгэх шаардлага тулгарч байна. Ингэснээр банкнаас зээл авч, зээлийн хүүд унамааргүй байна. Бололцоотой гэсэн болгосноороо идэвхи санаачлага, хурдтай ажиллах шаардлага гарч байгаа.

Л.Шагдаррагчаа – Өнөөдрийн байдлаар бүх үл хөдлөх хөрөнгөө банкны барьцаанд тавиад байна. Корпорацийн хөрөнгүүд 7-8 тэрбум төгрөгийн барьцааны үнэлгээтэй. Намуун дэнжийн банкны өрийг 9-р сар гэхэд дуусгаад барьцаа хөрөнгөө чөлөөлүүлж авах хэрэгтэй байна. Намуун дэнжийн барилгыг энэ ондоо орхиод Оюу толгойн ажилдаа хүчээ тавьж ажиллах саналтай байна. Та нөхөд энэ тал дээр саналаа хэлнэ биз. Эрдэнэбат захирал Шанхай хотод очоод нилээд амжилттай гэрээ хэлцэлүүдийг хийгээд ирсэн. Хөргөлттэй котейнерийн гэрээ, агуулахын материалын гэрээ, Айвенхоу-ийн хот дахь оффисийн засварын гэрээнүүдийг хийх болсон. Хаан банкнаас 1.2 тэрбум төгрөгийн зээл авахаар хөөцөлдсөн боловч Улаанбаатар банкны зээлээс болоод

буцсан байна. 5-р сарын Phase-I –ийн санхүүжилт болох 2.2 тэрбум төгрөгийг авбал санхүүгийн хувьд сайжрах төлөвтэй байгаа. Иймд цаг хугацаанд нь явуулж санхүүжилтээ түргэтгэх нь зүйтэй.

Ш.Үнэнбат – 2009 оны үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байсан тул асуух зүйл алга. Гэвч тодруулах хэдэн асуулт байна.

1. 2 тэрбум төгрөгийн зээлээ хэрхэн төлж барагдуулах төлөвлөгөө гаргасан уу?

2. Намуун дэнж болон бусад өр төлбөрийн дэлгэрэнгүй тооцоог өгөөрэй.

3. 2010 онд санхүүгийн шалгалт орно. Бэлтгэл хэр байгаа вэ?

4. Намуун дэнжийн шүүхийн процесс ямаршуу байгаа талаар мэдээлэл өгөөч.

5. Эрдэнэбат захирлын тайланд олон компани байгуулах талаар тусгасан байсан. Түүнийгээ дэлгэрэнгүй танилцуулаач.

Ш.Эрдэнэбат – 1-р асуултанд хариулъя. 5-р сард Айванхоу майнз компаниас 2.2 тэрбум төгрөгийн нэхэмжлэл өгөх ёстой. Түүнийгээ авчихаад 2 банкинд эхний ээлжинд 500, 500 сая төгрөгийг төлье гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

3-р асуултанд хариулъя. Санхүүгийн шалгалтын хувьд санхүүгийн албанаас гаргадаг дугаарт нь оруулаад орохоор бодож байгаа. Тэр болтол бэлтгэл ажлаа сайн хийх хэрэгтэй болно.

5-р асуултын хариулт: Олон компанийн хувьд ТУЗ-ийн дарга Шагдаррагчаа зөвлөхийн үйлчилгээгээрээ компани байгуулахыг дэмжиж байгаа. Одоо ч зөвлөхийн үйлчилгээ хийж байгаа. Өмнө байгуулсан 2 охин компани “Бадрал уул” ХХК, “Стил таур” ХХК-ийн хувьд үйл ажиллагаагаа явуулаад байж байгаа. Олон ажил аваад олон талд ажиллаад ирэхээр хяналт алдагддаг тал бий. Тиймээс сайн бодож байж шийдвэрлэх хэрэгтэй болно. Жишээлбэл: групп гэх мэт.

Д.Гэрэлцэцэг – 2-р асуултын хариулт: Зураг төсөл 8.2 сая, “Бармон” ХХК-д 142.0 сая, 2 иргэний орон сууцны төлбөрийн үлдэгдэл 30.0 сая, “Энэрэл мамоц” ХХК-д газрын төлбөр 336.0 сая, нийт 516.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Л.Шагдаррагчаа – 4-р асуултын хариулт: Намуун дэнжтэй холбоотой 4 шүүх хурал болсон. 1.79 тэрбум төгрөгийн төлбөр тавигдсан. Энэ хэрэгт хуулийн зөвлөх авч ажиллуулж байгаа. “Хаан зам” ХХК-ийн түрээсэлж байгаа байрыг битүүмжилэхээр хүмүүс очсон. Ирэх 1 дэх өдөр үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тухай албан бичиг хүргүүлнэ.

Чанаргүй бетон нийлүүлсэнтэй холбоотой 1.8 тэрбум төгрөгийн хохиролтой холбоотой шүүх хурал 2009 онд 7-8 удаа хуралдаад одоогоор Баянгол дүүргийн шүүхэд очоод байгаа. Хөндлөнгийн хяналт экспертиз орсон шалгаж байгаа.

Захиргааны хэргийн шүүхэд татварын өртэй холбоотой хэрэг байгаа. Үүнийгээ судалж үзээд шүүхээс татаж авах асуудлыг ярилцаж байна.

Ш.Ариунбат – Тайлангуудыг сонслоо. Ерөнхийдөө компанийн үйл ажиллагааны тухай ойлголт байсан. Тайлангуудаас илүү их мэдээлэл авлаа. Өр төлбөрөө төлөөд дахин зээл авахгүй байх хэрэгтэй.

Б.Бурмаа – Айвенхоу-той гэрээ байгуулахдаа хуулийн дагуу ажиллаарай.

Ш.Төгсбат – Надад асуух асуулт, тодруулах зүйл байхгүй.

С.Тунгалаг – Хэлэх зүйл байхгүй.

Л.Шагдаррагчаа: Өөр санал шүүмжлэл байхгүй бол тогтоол болон шийдвэрүүдийн төслөө батлая. 4, 5, 6, 7-р тогтоолын төслүүдийг санал нэгтэй батлав.

2010 оны бизнес төлөвлөгөөг 5-р сард багтаан батлах, өр төлбөрийг ондоо багтаан барагдуулах, үйл ажиллагааны хүрээг өргөтгөж ашиг орлого нэмэгдүүлэх талаар ТУЗ-д даалгаж шийдвэрлүүлье.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Хэлэлцсэн асуудлуудаар хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын тогтоолуудыг батлав.
2. 2010 оны бизнес төлөвлөгөөг энэ оны 5-р сард багтаан батлуулахыг ТУЗ-д даалгав.
3. ТУЗ болон хянан шалгагчийг улируулан сонгон ажиллуулах тухай тогтоол гаргаж баталгаажуулав.
4. Компанийн нарийн бичгийн дарга Н.Жадамба Оюу толгой төслийн менежерээр ажиллаж байгаа тул компанийн нарийн бичгээр корпорацийн менежер В.Мөнхгэрэлийг ажиллуулах шийдвэр гаргаж ТУЗ-ийн тогтоол гаргахаар болов.

5. СЗХороо болон МХБ-д компаний хувь нийлүүлэгчдийн хурлын материалыг хугацаанд нь хүргүүлэхийг В.Мөнхгэрэлд даалгав.

Хурал 13¹⁵ цагт дуусав.



Танилцсан.



Хурлын тэргүүлэгчдийн дарга.

Тэмдэглэл хөтөлсөн.

ТТБ1661-2069822

Нарийн бичгийн дарга.

Л.ШАГДАРРАГЧАА

В.МӨНХГЭРЭЛ

“БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр.

Дугаар 01

Улаанбаатар
хот.

Хурлын тэргүүлэгчид
батлах тухай.

ТОГТООХ нь:

1. Компанийн 2009 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх ээлжит хурлын тэргүүлэгчдийг хувь нийлүүлэгчдийн саналыг үндэслэн доорх бүрэлдэхүүнтэй баталсугай.

Хурлын тэргүүлэгчдийн дарга: Л.Шагдаррагчаа
Гишүүд Б.Бурмаа
Ш.Эрдэнэбат

2. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг удирдан зохион байгуулахыг хурлын тэргүүлэгчдэд зөвшөөрсүгэй.



Хурал зохион байгуулах
ажлын хэсгийн дарга.

Ш.Эрдэнэбат
Ш.Эрдэнэбат.
В.Мөнхгэрэл
Д.Гэрэлцэцэг

“БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр.

Дугаар 02

Улаанбаатар
хот.

Хэлэлцэх асуудлыг
батлах тухай.

ТОГТООХ нь:

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар доорх асуудлыг хэлэлцсүгэй.

1. ТУЗ-ийн тайлан
2. 2009 оны компанийн үйл ажиллагааны тайлан, 2010 оны үйл ажиллагааны чиглэл
3. 2009 оны санхүүгийн тайлан
4. Хянан шалгагчийн тайлан
5. ТУЗ-ийн гишүүд, хянан шалгагчийг улируулан томилох тухай
6. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийг батлах тухай
7. Бусад асуудал, мэдээлэл



Хурлын тэргүүлэгчдийн

Дарга.

Гишүүд.

БАРИЛГА

ХК

ТТБ1661-а 2069822

Л.Шагдаррагчаа

Б.Бурмаа

Ш.Эрдэнэбат

“БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр.

Дугаар 03

Улаанбаатар
хот.

Хурлын дэг
батлах тухай.

ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн тайлан – ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа – 10 минут
2. 2009 оны компанийн үйл ажиллагааны тайлан, 2010 оны үндсэн чиглэл – Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат – 10 минут
3. 2009 оны санхүүгийн тайлан – Ерөнхий санхүүч Д.Гэрэлцэцэг – 10 минут
4. Хянан шалгагчийн тайлан – Хянан шалгагч С.Тунгалаг – 5 минут
5. ТУЗ-ийн гишүүд, хянан шалгагчийг улируулан сонгох тухай – цаг тогтоохгүй.
6. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийг батлах тухай – Цаг тогтоохгүй
7. Бусад асуудлын мэдээлэл – Цаг тогтоохгүй.
8. Санал шүүмжлэл – Хүн бүр 3 минут
9. Хурлыг 2010 оны 04-р сарын 23-ны өдрийн 10⁰⁰ цагаас эхлэн цаг тутам 15 минутын завсарлагатай хийж 14⁰⁰ цагт дуусгана.



Хурлын тэргүүлэгчдийн

Дарга.

CORP Гишүүд.

БАРИЛГА

ЖА

ТТБ1661.т. 2069822

Л.Шагдаррагчаа

Б.Бурмаа

Ш.Эрдэнэбат

“БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр.

Дугаар 04

Улаанбаатар
хот.

Тайлангууд батлах тухай.

“Барилга” корпораци ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас
ТОГТООХ нь:

1. Компанийн 2009 оны үйл ажиллагааны тайлан, 2010 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл, ТУЗ, Хянан шалгагчийн хэлэлцүүлсэн тайланг баталсугай.
2. Тус корпорацийн 2009 оны санхүүгийн тайланг баталсугай.
3. ТУЗ-д даалгах нь:

а/ 2010 оны үйл ажиллагааны чиглэл, бизнесийн нарийвчилсан төлөвлөгөөг 2009 оны 05-р сард багтаан хянаж батлах;

б/ Компанийн өр авлагыг барагдуулах идэвхитэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

в/ “Оюу толгой” төслийн К-524 тоот гэрээний хэрэгжилтийг хянаж удирдлагаар хангах;

г/ “Намуун дэнж” төслийн барилгыг гүйцээн худалдах, банкны зээл хүүг хүндрэл учруулахгүйгээр 3-р улиралд багтаан төлж барьцаа хөрөнгө чөлөөлөх асуудлыг 5-р сард багтаан шийдвэрлэх;

4. ТУЗ, Хянан шалгагчид даалгах нь:

а/ Компанийн жил, улирлын тайлан балансад дүн шинжилгээ хийж ажиллах;

б/ Санхүүгийн тайлан балансын орлого, зарлага, ашигт дүгнэлт хийх;

в/ Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын шийдвэрт хяналт тавих;



Хурлын тэргүүлэгчдийн

Дарга.
Гишүүд.

(Handwritten signatures)
Л.Шагдаррагчаа
Б.Бурмаа
Ш.Эрдэнэбат

“БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр.

Дугаар 05

Улаанбаатар
хот.

ТУЗ-ийн гишүүд, хянан
шалгагчийг батлах тухай.

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын 2010 оны 04-р сарын 23-ний өдрийн
шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Барилга” корпораци ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга
гишүүдийг болон Хянан шалгагчийг хувь нийлүүлэгчдийн хурлын
шийдвэрийг үндэслэн 100 хувийн саналаар доорх бүрэлдэхүүнтэй
улируулан сонгож баталсугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
Гишүүдэд

Л.Шагдаррагчаа
Ш.Эрдэнэбат
Б.Бурмаа
Ш.Үнэнбат
Ж.Жадамба
Ш.Ариунбат
Н.Жадамба
Ш.Төгсбат
Б.Энхболд

2. Корпорацийн хянан шалгагч

С.Тунгалаг



Л. Шагдаррагчаа
Л.Шагдаррагчаа
Б. Бурмаа
Б.Бурмаа
Ш. Эрдэнэбат
Ш.Эрдэнэбат

**“Барилга” корпорацийн төлөөлөн удирдах зөвлөлөөс
2009 онд хийсэн ажил, 2010 оны зорилтын тухай**

ТУЗ-ын дарга Л.Шагдаррагчаа

Хувьцаа эзэмшигч эрхэм нөхдөө.

“Барилга” корпорацийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, 2008-2009 онд үүссэн Дэлхийн эдийн засаг санхүүгийн хямралын Монголд нөлөөлсөн хор уршиг, Барилгын салбарт бий болсон хөрөнгө оруулалт-санхүүгийн зогсонги хүнд байдлаас бага хохиролтой гарах, банк санхүүгийн байгууллагуудаас үзүүлж байгаа зээл төлбөрийн дарамтыг давж гарах, энэ чиглэлээр үүссэн нөхцөл байдлын хууль эрх зүйн маргааныг шийдвэрлэх, өөрийн өмч хөрөнгийн ашиглалтын өгөөжийг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулахад ТУЗ гол анхаарлаа хандуулж ажилласан болно. Хэдийгээр ТУЗ шаардлагатай үед хуралдаж байгаагүй ч компаний өдөр тутмын үйл ажиллагааг мэдэрч хянаж байсан гэж болно.

2009 он бол манай корпорацийн үйл ажиллагааны их чухал үүрэг хариуцлагатай жил байсныг та бүгд мэдэж байгаа. Корпораци энэ жилд үүссэн хүндрэл бэрхшээлийг ухаалгаар давж нэр төртэй үдсэн гэж болно. Учир нь 2009 онд “Барилга” корпорацийн үйл ажиллагаа өмнөх жилүүдээс эрс хумигдаж, барилга орон сууцны ажил бүхэлдээ зогссон боловч түүнийг сөрөн хямралт байдал болон Барилгын салбарын мөнгөний хомсдлоос ирсэн хүнд цохилт дарамтаас ухаалгаар зайлан гарч, дампууралын нөхцөл байдлаас нэр төртэй гарч өөрийн хамгаалалт дархлааг бий болгож чадсан гэж хэлж болохоор боллоо.

Тайлант хугацаанд ТУЗ 2 удаа цуглаж, хоёр удаа эчнээ хуралдаж нийт 6 асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргаснаас эдгээр асуудлууд бүрэн биелэгдсэн байна. Энэ хугацаанд ТУЗ-ийн ихэнх гишүүд корпорацийн өдөр тутмын ажилтай ажил төрлийн байнгын холбоотой ажилладаг нэгдмэл сонирхолтой этгээдүүд тул ТУЗ-ийн хурлыг хуралдуулах болон шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хянах ажиллагаа маш дөхөм хялбар байсныг хэлэх ёстой.

Тус корпорацийн өмчлөл, түүний төлөөллийн талаар нилээд өөрчлөлт гарсан байна. Тус корпорацийн 40662 ширхэг хувьцааны 96 хувь нь 7 хүнд төвлөрч, 4 хувь нь 16 этгээдэд эзэмшигдэж байна. Энэ нь компани улам бүр хувийн төвлөрсөн шинжтэй болж байгааг харуулж байгааг илтгэж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор шинээр батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн хууль”-ийн 11 дүгээр зүйлд заасны дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс тэдний хувьцааг тендер санал гарган төвлөрүүлэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай болсонг харуулж байна. Ийм оролдлогыг зохих журмын дагуу 2008-2009 онд хийсэн боловч гишүүд цөөн тооны хувьцаагаа худалдахгүй байх сонирхолтой байсан, энэ байдал нь корпорацийн өнөөгийн ажиллагаанд төдийлөн нөлөөлөөгүй.

Тайлант хугацаанд корпораци 256.0 сая төгрөгийн барилгын ажил гүйцэтгэж, байгууллагын 15 ажилчныг тогтвортой ажлын байраар хангаж

15000м² талбайтай 159 айлын үйлчилгээтэй орон сууцны “Намуун дэнж” төслийг бүх төрлийн оролдлогыг хийсэн боловч эдийн засаг мөнгө санхүүгийн хүндрэлээс санхүүжилтийн эх үүсвэр олдсонгүй, сууц гэрээлэх иргэдэд банкнаас олгож байсан зээл бүрэн зогссонтой холбогдон 2009 онд энэ барилгын ажлыг бүхэлд нь зогсоосон.

Лиценци зэмшигч компани болон Монголын засгийн газрын хооронд байгуулагдах тогтворт байдлын гэрээний хүлээлттэй холбоотойгоор “Оюу толгой-Барилга” төсөл зогсож 2009 онд ихээхэн хүлээлт үүсч барилгын чиглэлээр тодорхой үйл ажиллагаа хийсэнгүй.

Тайлант хугацаанд төсөвт 28.1 сая төгрөгийн татвар шимтгэл төлж, 11 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь хувьцааны ноогдол ашиг хуваах, удирдлага болон ажилтнуудад үр дүнгээс урамшуулал олгогдохгүй болж байна. Хэдийгээр жилийн санхүүгийн тайлангаар ийм алдагдалтай гарсан боловч 2009 онд корпорацийн захирал, санхүүч нар өмнөх жилүүдэд хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, Намуун дэнж төсөлд байгууллага иргэдээс оруулсан хөрөнгө оруулалтын өрийг барагдуулах талаар ихээхэн санаачлагатай ажилласан, санхүүгийн хямралаас үүдэж барилгын салбар 2009 онд бүхэлдээ зогссонтой холбоотойгоор барилгын ажлаас орох орлого тасалдсантай холбоотойгоор алдагдал гарсанг корпорацийн захиргаа муу ажилласан гэж дүгнэх үндэслэл байхгүй бөгөөд харин хямралтай нөхцөлд боломжийн хэмжээнд ажилласан, хохирол багатай даван туулсан гэж үзэх бүрэн үндэслэл байгаа юм.

Корпорацийн гүйцэтгэх захирлын зүгээс санхүү-эдийн засгийн хүндрэлийг даван туулах, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх, өр төлбөрийг барагдуулах, өмч хөрөнгийнхөө үнэлэмжийг нэмэгдүүлэх, бизнесийн шинэ чиглэл нээх зорилгоор “Оюу толгой төслийн” барилга байгуулалтын чиглэлээр маш идэвхитэй ажилласан гэж үзэж байна. Өнөөдөр ОТТ-ийн барилгын болон хангамж үйлчилгээний үндсэн нэг, хавсралт 3 гэрээ хэлцэл байгуулж 10 орчим тэрбум төгрөгийн ажлыг гүйцэтгэж эхлээд байгаа нь Намуун дэнж төсөлд авсан зээлийн өр төлбөрийг 2010 онд багтаан төлж, үл хөдлөх хөрөнгүүдээ зээлийн барьцаанаас чөлөөлөн, улмаар санхүүгийн зохих хуримтлал үүсгэх, бизнесээ улам өргөтгөх сайхан боломжийг нээсэн гэж дүгнэх ёстой.

Түүнчлэн нийт 810.0 сая төгрөгийн үнэтэй 5 машин техник, тээврийн хэрэгсэл, 120 нэрийн ажлын багаж тоног төхөөрөмж, 7 түр барилга байгууламжийг ООТ-д зориулан худалдан авч корпорацийн өөрийн хөрөнгийн хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлсний зэрэгцээ одоогоор 110 нарийн мэргэжлийн ажилчин 170 ИТА-тай болгосон зориуд мэдээлэх нь зүйтэй.

Хүндрэлтэй хомсдолтой 2009 оныг эрсдэл багатай даван туулахад ТУЗ-ийн гишүүн Ш.Үнэнбат зээлийн төлбөрийг төлөх, эх үүсвэрт зориулан өөрийн “Бармон” ХХК-ийн хөрөнгийг барьцаалах, ОТТ-ийн хангамжийн ажилд биечлэн оролцох зэргээр бодит сэтгэл гаргасан туслалцаа үзүүлсэнг хэлэх ёстой.

Эдгээр бодит ажил, үр дүнгүүд нь корпорацийн захиргааны хүмүүсийн идэвхитэй үр бүтээлтэй санаачлагатай байдалтай шууд холбоотой гэж ТУЗ үзэж байгаа болно. ТУЗ болон корпорацийн захиргаа 2009 онд ажил үүргээ биелүүлсэн гэж үзэх боломжтой байна.

2010 онд ТУЗ болон захиргааны өмнө нэн тэргүүнд банкуудад төлөх 2,4 тэрбум төгрөгийн банкны зээлийн өрийг бизнесийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, хэмнэлтийн горим мөрдүүлэх замаар бүрэн төлж, барьцааны хөрөнгүүдийг яаралтай чөлөөлөн, дахин бизнесийн эргэлтэнд ашиглах замаар корпорацийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ашиг орлого олох асуудал тулгамдсан байгаа. Энэ зорилгоор ТУЗ болон Гүйцэтгэх захирлын зүгээс үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг доорх байдлаар томъёолж байна.

Корпорацийн ТУЗ нь 2010 онд доорх үндсэн чиглэл баримтлан ажиллах зорилттой байна. Үүнд:

- Үйл ажиллагааныхаа тогтвортой байдлыг баталгаажуулж өргөжүүлэх, үүний тулд ажлын төлөвлөлт ба гүйцэтгэлийн хяналтын нарийн систем тогтоож мөрдүүлэх,
- Нийт 9177,0 тэрбум төгрөгийн өртөгтэй ОТТ-ийн “К-524” гэрээ болон түүний хавсралт дагалдах гэрээт ажлыг хэрэгжүүлснээр корпорацийн ашигт ажиллагааны түвшинг 3 дахин нэмэгдүүлэх
- Үйл ажиллагааг үйлдвэрлэлд ойртуулж тодорхой харьцангуй бие даасан байлыг бэхжүүлэх зорилгоор 3-аас доошгүй салбар буюу охин компани байгуулах, ажил төрлийн байнгын холбоотой болон хувь эзэмшигч гишүүн компанууд, охин компануудыг хүрээлэлдээ багтаасан бизнесийн бүлэглэл “групийн” зохион байгуулалтанд оруулах
- Корпораци цаашдаа Барилга хөрөнгө оруулалтын “Зөвлөх үйлчилгээний төв”, барилгын материалын экспорт импорт-прокурементийн ажиллагааны чиглэлд “БАРМАТ Сервис” бөөний худалдааны салбар байгуулан ажиллах,
- “Оюу-толгой-Барилга” төслийг үргэлжлүүлж, нэмж ажил үйлчилгээний гэрээ авах замаар 2010 онд 15,0 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 1,0 тэрбумаас доошгүй ашиг олох
- Намуун дэнж төслийн өр төлбөрийг бүрэн барагдуулж, барьцаа хөрөнгүүдийг чөлөөлж, эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар тус барилгын ажлыг дуусгаж худалдах юмуу сонирхогч этгээдэд уг төслийг худалдах
- Төслийн тендерт идэвхитэй оролцож гишүүн компануудыг ажлаар хангах үйлчилгээ эрхлэх
- Барьж буй орон сууцыг зах зээлийн шаардлагыг хангахуйц өндөр чанартай барьж өрсөлдөх чадавхаа нэмэгдүүлэх, шинэ дэвшилтэт материал, тэргүүний технологи, инновацийн арга хэрэгслийг хэрэглэх, гадаад харилцааг өргөжүүлэх,
- Орон сууцны төсөл хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын интерал систем аргыг улам бүр зүгшрүүлэн төслийн төв удирдлагаас талбайн удирдлага хүртэлх бүх түвшинд бүрэн хэрэгжүүлэх,

Эдгээр чиглэлээр ажилласнаар 2010 онд гүйцэтгэх ажлын хэмжээг 2008 оны түвшингээс 2 дахин нэмэгдүүлэх, ингэснээр бизнесийн үйл ажиллагааныхаа эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийн 50-оос доошгүй хувийг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хангах, улмаар зээлийн барьцаа, баталгааг өөрийн хөрөнгө хувьцаагаар гаргах бололцоотой болох зэрэг болно.

Иймд хувьцаа эзэмшигчид, ТУЗ, корпорацийн захиргаа урьд өмнөхөөс илүү санаачлагатай идэвхтэй ажиллах шаардлага тулгарч байгаа хэлэх нь зүйтэй.

Өнөөдрийн хурлаар та бид ноогдол ашиг хуваарилах, жилийн үр дүнгийн шагнал олгох, цэвэр ашгийн хуваарилалтын талаарх саналуудыг хэлэлцэж шийднэ. Компаний ТУЗ, Гүйцэтгэх захирал, хянан шалгагч нарыг энэ хурлаар дахин сонгож томилох шаардлага байхгүй, ажлаа сайн гүйцэтгэж байгаа гэж үзсэн. Өнгөрсөн жилд олсон ашиг өмнөх жилүүдээс бага гарч байгаа тул 2008 оны ашгийн хуваарилалтаас 2-3 бага хуваахаар санал оруулж байгаа. Энэ үр дүнгийн хувь ноогдол ашиг нь та бидний хийсэн зүйлд бус хийхээр төлөвлөж байгаа зүйлд хуваарилж байгаа гэж ойлгож, корпорацийн захиргаа, албан хаагчид шаардлагад нийцэн ажиллах нь зүйтэй.

Хурлын ажиллагаанд амжилт хүсье.

2010 оны 4 дүгээр сар 23

Улаанбаатар хот

Корпорацаас 2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын тухай

Ш.Эрдэнэбат – Гүйцэтгэх захирал

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчидээ.

2008 оны 10 сараас эхлэсэн санхүү-Эдийн засгийн хямралт байдал, Монгол банкнаас хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын үр уршгаар ажил хүлээж авсанаас хойш өнөөдрийг хүртэл барилгын салбар үндсэндээ бүрэн зогсож, корпорацийн үйл ажиллагааг төлөвлөсний дагуу явуулж, ашиг орлого олох боломж үнэндээ гарсангүй. Барилгын салбарын, тэр дундаа орон сууцны барилгын зээл санхүүжилт одоо болтол жигдрээгүйгээс байдал сайжраагүй хэвээр байсаар байна. Энэ талаар ТУЗ-ийн тайланд тодорхой гарсан, мөн энэ хуралд хэлэлцүүлэх санхүүгийн тайланд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гол үзүүлэлтүүд болон өр авлага барагдуулалтыг оруулсан тул энд давхар ярих шаардлагагүй гэж үзэж байна.

2010 он бол корпорацийн хувьд бизнесийн үйл ажиллагааны маш хариуцлагатай, зээл төлбөрөө барагдуулах, бизнесээ тэлж өргөжүүлэх, үл хөдлөх хөрөнгийнхээ хөрвөх чадамжийг ашиглан хөрөнгө босгох баталгаат байдлыг хангаж, санхүүгийнхээ чадавхийг 3-4 дахин нэмэгдүүлэх асар том зорилгыг дэвшүүлж хэрэгжүүлэх жил байх болно. Энэ зорилгоо хэрэгжүүлэхдээ дараах зорилтыг барьж ажиллахаар хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж байна. Үүнд:

- Юуны өмнө одоо хэрэгжүүлж байгаа ОТТ-ийн болон бусад орлогоороо 2 банкнаас 2008 онд авсан зээлийн өр 2.4 тэрбум төгрөгийг 2010 оны 9 сард багтаан төлж, барьцааны хөрөнгүүдийг чөлөөлөн дахин эргэлтэнд оруулах замаар хөрөнгийн байнгын хангалттай эх үүсвэртэй болох асуудал эн тэргүүнд тавигдаж байна.
- ОТТ-ийн хүрээнд худалдан авах 810.0 сая төгрөгийн үнэ бүхий нэр төрлийн машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл түр барилга байгууламжтай болсноор корпорацийн үндсэн хөрөнгийг 2500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, нэг хувьцааны баталгаажсан үнийг 10 хувь дээшлүүлнэ.
- Удаан хугацаагаар хүлээлтэнд байсан “Оюу-толгой барилга” төслийг үргэлжлүүлж, 2 жил шахам хугацаанд зогсоосон орон сууцны төсөл хэрэгжүүлэх, 16000м² талбайтай үйлчилгээтэй орон сууцны “Намуун дэнж” төслийг 1-2 жилийн хугацаанд хүлээх хэрэгтэй болж байна.
- ОТТ-ийн шугамаар үр ашигтай ажиллаж Өмнийн говьд баригдаж байгаа “Оюу толгой” төслийн барилгын болон хангамж үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийн тендерүүдэд оролцож 15 тэрбумаас доошгүй төгрөгийн гэрээт ажлыг олж гүйцэтгэхээр ажиллаж байна. Энэ чиглэлээр Бармон ХХК, “Нэшнл катеринг сервис”, Бадарал-Уул” ХХК-уудад ажлын байр олж ажиллуулна. Шинээр 200-250 шинэ ажлын байр бий болгох юм.
- Өөрийн охин компани болох Стилл таувер ХХК, Бадрал уул ХХК-ийн ажлын далайц хэмжээг өргөжүүлж тодорхой төсөлд оруулцуулж

үйл ажиллагаа болон бие даан ажиллах чадвар боломжийг нь бүрэн хангахад анхаарна.

- Корпорацийн үйл ажиллагааг бизнест ойртуулах, ажилтнуудын идэвхи санаачлага, сонирхлыг нэмэгдүүлэх экспорт-импорт-прокурементийн нэг, Үл хөдлөх хөрөнгийн зуучлал-орон сууцны хангалтын нэг, барилгын зөвлөх үйлчилгэний нэг охин компаныг байгуулах зорилтыг тавьж байна. Ингэснээр корпораци нь төв толгой компаний үүргээ чанартай зөв хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.
- Монгол улсын барилгын тухай шинэ хуульд барилгын төслийн ажиллагаанд зөвлөх үйлчилгээг байхаар баталгаажуулсантай холбоотойгоор корпораци өөрийн зөвлөх тэргүүлэх ажилтнуудын хүч боломжид тулгуурлан зөвлөх үйлчилгээ-зураг төслийн компани байгуулах бодолтой байна.
- 40000 орон сууцны хөтөлбөрт хамрагдаж байгаа болон “Оюу толгой” болон “Намуун дэнж төслүүдэд шаардлагатай бараа материалыг дотоод гадаадаас хангах үүрэгтэй хангамж үйлчилгэний компани байгуулах асуудлыг судлан шийдвэрлэнэ
- Намуун дэнж төслийн борлуулалтыг хариуцах нэгж бас байгуулж болно гэж үзэж байна.
- Корпорацийн үл хөдлөх хөрөнгийг банкны зээлийн барьцаанаас чөлөөлөх, зээлийн өр төлбөрийг барагдуулах, хөрөнгийн ашиглалтыг эрс сайжруулж, хөрөнгийн нэгж тутмаас олох ашиг орлогыг 20-аас доошгүй хувь нэмэгдүүлнэ
- Ажил төрлийн холбоотой болон гэр бүлийн гишүүд, охин компаниудыг хамарсан барилга хөрөнгө оруулалтын бизнесийн группийн зохион байгуулалтанд оруулах санал солилцох ажил хийж байна.

